

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго:	Хүний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, хүний нөөцийн бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ (1 хүн, 3 сар)
Төслийн нэр:	“Ухаалаг засаг” төсөл
Дэд бүрэлдэхүүн хэсэг:	Үндэсний статистикийн хороо, “Статистикийн байгууллагын мэдээлэл боловсруулах чадавхийг бэхжүүлэх” дэд бүрэлдэхүүн хэсэг
Төсөл хэрэгжүүлэгч:	Монгол Улсын Засгийн газар
Төслийн дугаар:	5483-MN
Үйл ажиллагааны дугаар:	Төслийн худалдан авалтын төлөвлөгөөний 3.2.7 с
Байршил:	Монгол Улс, Улаанбаатар хот
Захиалагч:	Үндэсний статистикийн хороо

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Статистикийн байгууллага нь улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны талаарх статистикийн мэдээллээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад адил тэгш үйлчилдэг төрийн байгууллага болно.

Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрддэг бөгөөд сумдад статистикийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын уг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэдэг. Өнөөдрийн байдлаар статистикийн байгууллагад 320 ажилтан ажиллаж байгаа бөгөөд улс орны хөгжлийн гол тулгуур болсон статистик мэдээллээр ханган ажиллаж буй байгууллагын ажилтнуудын чадавхийг байнга тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг” төслийн хүрээнд “Статистикийн байгууллагын мэдээлэл боловсруулах чадавхийг бэхжүүлэх” төслийг 2015 оноос амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн үндсэн зорилтын нэг нь статистикийн байгууллагын боловсон хүчний чадавхийг үндэсний болон олон улсын түвшинд бэхжүүлэх явдал юм.

Төслийн хүрээнд статистикийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр үндэсний болон орон нутгийн түвшинд сургалт зохион байгуулах, олон улсын сайн туршлага судлах, нэвтрүүлэх, хүний нөөцийн бодлого боловсруулахад дэмжлэг

үзүүлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд статистикийн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, тогтворжуулах, хөгжүүлэх, хүний нөөцийн удирдлагыг цогцоор нь хэрэгжүүлэх хүний нөөцийн цогц бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөх сонгон шалгаруулах гэж байна.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Статистикийн байгууллагын хүний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах, хүний нөөцийн цогц бодлого боловсруулах, чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулахад оршино.

Үндэсний зөвлөх нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Төв болон орон нутгийн статистикийн байгууллагын институцийн бүтэц тогтолцоо, хүний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх ажлын төлөвлөгөө, аргачлал боловсруулах, холбогдох ажилтнуудад танилцуулах, зөвшилцөх, батлуулах;
2. Статистикийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулах;
3. Төв болон орон нутгийн статистикийн байгууллага дээр мөрдөж буй дүрэм, зарчмуудыг хянаж, давхцаж байгаа эсэхийг нягтлан үзэж шинэчлэх
4. Албан хаагчдын хууль, эрх зүй, албан хэрэг хөтлөлт, архив, албан бичгийн мэдлэгийг дээшлүүлэх,

Зөвлөх үйлчилгээний хүрээнд төв болон орон нутгийн статистикийн байгууллагад дээрх 4 ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Төв болон орон нутгийн статистикийн байгууллагын институцийн бүтэц тогтолцоо, хүний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх ажлын төлөвлөгөө, аргачлал боловсруулах, холбогдох ажилтнуудад танилцуулах, зөвшилцөх, батлуулах;
 - Төв болон орон нутгийн статистикийн байгууллагын институцийн бүтэц тогтолцоо, хүний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, үр дүнг танилцуулах
 - Албан тушаалын тодорхойлолт боловсруулж, танилцуулах
2. Статистикийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулах
 - Хэрэгжүүлэх шат бүхий ажлын төлөвлөгөө боловсруулах
 - Статистикийн салбарын хүний нөөцийн судалгаа явуулах
 - Хүний нөөцийг чадавхыг тодорхойлсон үнэлгээ хийх
 - Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх
 - Нийгмийн хамгаалал, хангамжийн талаар үнэлгээ хийх
3. Төв болон орон нутгийн статистикийн байгууллага дээр мөрдөж буй дүрэм, зарчмуудыг хянаж, давхцаж байгаа эсэхийг нягтлан үзэж шинэчлэх

- Бүх дүрэм, зарчмуудыг жагсааж, тэдгээрийн хууль, эрх зүйн үндэслэлд үнэлгээ хийх
 - Дүрэм, зарчмуудын хоорондоо нийцэж, давхцаж байгааг нягталж үзэх
 - Шинэчлэн сайжруулах
4. Албан хаагчдын хууль, эрх зүй, албан хэрэг хөтлөлт, архив, албан бичгийн мэдлэгийг дээшлүүлэх,
- Албан хаагчдын хууль, эрх зүй, , албан хэрэг хөтлөлт, архив, албан бичгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх
 - Албан бичгийн бүртгэлийг хэрхэн хөтлөх тухай албан хаагчдад зориулсан товч гарын авлага боловсруулах
 - Байгууллага хөтлөх ёстой албан ёсны бүртгэлийн жагсаалтыг тодорхойлох
 - Албан ёсны бүртгэл, архивыг стандарт архивын нэгжээр зохион байгуулах
 - Байгууллагын хөтлөх ёстой албан хэрэг хөтлөлтийн баримт бичгийн тайланг гаргах
 - Албан ёсны бүртгэлээс дутуу, алга болсон жагсаалтыг гаргах

3. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Үндэсний зөвлөхийн ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэх ажлаас дараах үр дүн гарах бөгөөд холбогдох тайланг Монгол, Англи хэлээр бэлтгэн ҮСХ болон “Ухаалаг засаг” төслийн нэгжид хүргүүлнэ. Үүнд:

- Төв болон орон нутгийн түвшинд статистикийн байгууллагын өнөөгийн байдлын дүн шинжилгээ хийгдсэн байх;
- Байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага, хөгжүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулсан байх;
- Хүний нөөцийн цогц бодлого боловсруулагдсан байх /Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөр/;
- Хэлэлцүүлэг, уулзалт, сургалт зохион байгуулагдсан байх

4. ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 3 сар

ЭХЛЭХ ХУГАЦАА: 2019 оны 10 сар

5. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зөвлөх нь ҮСХ-той гэрээ байгуулж ажиллах ба тус хорооны Тамгын газарт ажлаа тайлагнана. ҮСХ нь зөвлөхийг ажлын байраар хангаж, шаардлагатай туслалцааг төслийн нэгжээс үзүүлнэ.

6. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх иргэн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүний нөөц, төр, бизнесийн удирдлага, эрх зүй, эдийн засаг болон холбогдох чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Байгууллагын төлөвлөлт, хүний нөөц, хөгжлийн бодлого боловсруулах чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Ажлын байранд дүн шинжилгээ хийж, ажлын байрны тодорхойлолт боловсруулж байсан туршлагатай;
- Бодлогын баримт бичиг боловсруулах, судалгаа хийх, санал дүгнэлт гаргах чадвартай байх;
- Менежментийн тогтолцооны стандартын чиглэлээр сургалт зохион байгуулж байсан туршлагатай;
- Зөвлөх үйлчилгээний тогтсон хугацааны хүрээнд ажлын ачаалал даах чадвартай;
- Хувийн зохион байгуулалт сайтай ба багаар ажиллах чадвартай;
- Монгол, Англи хэлний бичгийн ур чадвар сайтай байх.

7. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Зөвлөх үйлчилгээний төлбөрийг үр дүнд суурилсан төлбөрийн нөхцлөөр хийнэ. Ажлын хөлсийг төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна. Зөвлөхийн ажлын хөлсийг дараах үе шаттай олгоно:

1 дэх санхүүжилт: 10%-ийг гэрээнд гарын үсэг зурснаар;

2 дахь санхүүжилт: 10%-ийг ажлын төлөвлөгөөгөө боловсруулж, батлуулснаар;

3 дахь санхүүжилт: 30%-ийг Үнэлгээний тайлан, бодлогын баримт бичгийг хүлээлгэн өгснөөр,

4 дэх санхүүжилт: 50%-ийг Хүний нөөцийн цогц бодлого боловсруулж, ажлын даалгаварт заасан бүх ажил хийгдэж, ажлын эцсийн тайлан хүлээлгэн өгснөөр (цаасан болон электрон хэлбэрээр)